

**ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ДЭНДЭВИЙН ГАНПҮРЭВИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (Биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
НЭГ. "ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ДЭД БҮТЭЦ, ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.	Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Гаалийн ерөнхий газарт хүргүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу Гаалийн ерөнхий газрын стратеги төлөвлөгөө, 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, газрын үндсэн чиг үүргийг үндэслэн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилт, 61 арга хэмжээтэй боловсруулан Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулсан. Тус газрын 2023 оны хагас жилийн гүйцэтгэлийн тайланг "Захиргаа, дотоод ажлын систем" программд байршуулж, Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн. Мөн Засгийн газрын 218 дугаар тогтоол, Засгийн	1.Газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг ГЕГ-ын даргын 2024 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан шалгуурын дагуу хугацаанд нь төлөвлөнө. 2.Гүйцэтгэлийн тайлан, үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийн биелэлтийг хугацаанд нь үнэн зөв тайлагнана.	Гаалийн ерөнхий газрын стратеги төлөвлөгөө, 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, газрын үндсэн чиг үүргийг үндэслэн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилт, 60 арга хэмжээтэй боловсруулах ажлын хариуцсан гаалийн улсын байцаагчтай хамтран гүйцэтгэж, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан журамд нийцүүлэн Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулсан. Тус газрын 2024 оны хагас жилийн гүйцэтгэлийн тайлан гаргах, нэгтгэх ажлыг зохион байгуулж, хянуулан ГЕГ-ын Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн. "Захиргаа, дотоод ажлын систем" программд байршуулсан. Тус гаалийн газрын 197 албан хаагч төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын 301 дүгээр тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан журмын дагуу батлуулсан. Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө баталгаажснаас хойш тус газарт шилжин ирсэн, шинээр томилогдсон 12 албан хаагчдад заавар, зөвлөгөө өгч ЗГХЭГ-ын даргын 2023 оны 98-р тушаалын 1 дүгээр	2024.01.01 2024.11.30	100

			<p>дугаар тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан журмын дагуу газрын 185 албан хаагч төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан биелэлтийг гарган дүгнүүлсэн.</p>		<p>хавсралтаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ын 2.8 дахь заадтын дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөг хийлгэж баталгаажуулах ажлыг гүйцэтгэсэн.</p> <p>Газрын 2024 оны эхний хагас жилийн биелэлт гаргахтай холбогдуулан албан хаагчдад ГЕГ-ын даргын 2024 оны А/190 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан "Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал"-ын талаар зөвлөгөө, зөвлөмж өгч, журмын хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>Мөн газрын даргын 2023.12.05-ны өдрийн А/37 дугаар тушаалаар байгуулагдсан "Үнэлгээний хороо"-ны нарийн бичгийн даргаар ажиллаж албан хаагчдын эхний хагас жилийн тайланд үндэслэн албадын дарга нарын үнэлгээ өгч баталгаажуулсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний хуудас"-ыг хүлээн авч үнэлгээний хорооны баталгаажуулалт хийх ажлыг зохион байгуулсан. Нийт 228 албан хаагчийг үнэлсэн үнэлгээний дүнг баталгаажуулж, удирдлагуудад танилцуулан дүн, мэдээг холбогдох албан хаагчид өгсөн. Эхний хагас жилд үнэлэгдсэн Төрийн тусгай 195 албан хаагчаас 80-90 оноогоор дүгнэгдсэн 9, 90-100 оноогоор үнэлэгдсэн 186, Төрийн үйлчилгээний 33 албан хаагчаас 80-90 оноогоор дүгнэгдсэн 4, 90-100 оноогоор дүгнэгдсэн 29 албан хаагч, эрүүл мэндийн шалтгаанаар дүгнэгдээгүй 1 албан хаагч тус тус байна. Үнэлгээний багаас албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээний мэдээлэх хуудсыг нэгтгэн гаргаж, "Маш сайн" үнэлэгдсэн 26 албан хаагчийг төрийн дээд болон салбарын шагналд, 10 албан хаагчийг Мөнгөн болон бусад хэлбэрийн шагнал, урамшуулал олгуулахаар нэрсийн жагсаалтыг гарган удирдлагад санал хүргүүлсэн.</p> <p>Жилийн эцсийн биелэлтийг холбогдох журмын дагуу ГЕГ-ын ЗУГ-аас ирүүлсэн чиглэлийн</p>	
--	--	--	---	--	--	--

					дагуу гарган цаг хугацаанд нь программд оруулсан. Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг албапын дарга нараар дүгнүүлэх ажил хийгдэж байна.		
2	Хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр зохион байгуулах сургалтыг хариуцах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1.2023 оны сургалтын төлөвлөгөө"-г албан хаагчдын гаалийн хэргийн мэдлэгийг дээшлүүлэх, гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм, сахилгыг чанд сахих, хувь хүний хөгжлийг дэмжих зорилгоор боловсруулан 02 дугаар сарын 20-ны өдөр газрын даргаар батлуулж ажилласан. 2.2023 оны 11 дугаар сарын 30-ны байдлаар сургалтын төлөвлөгөөний дагуу нийт 60 удаагийн 18 сургалтад давхардсан тоогоор 1974 удирдах албан тушаалтан, гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч болон албан хаагчид хамрагдсан. 3.Сургалтыг тус гаалийн газрын алба бүр сургалтын материал, хөтөлбөр боловсруулан нийт албан хаагчдыг идэвхтэй хамруулан зохион байгуулж ажилласан.	1.Албадууд болон албан хаагчдаас сургалтын санал авч нэгтгэн 2024 оны сургалтын төлөвлөгөө"-г боловсруулан газрын даргаар батлуулан хэрэгжүүлнэ. 2.Сургалтын төлөвлөгөөнд 2024 оны эхний хагас жилд зохион байгуулахаар төлөвлөсөн сургалтуудыг зохион байгуулж албан хаагчдыг хамруулсан байна. 3.Сургалтын төлөвлөгөөний биелэлтийг эхний хагас жилээр нэгтгэж тайлагнасан байна.	-Албан хаагчдаас цахимаар, албадуудаас бичгээр санал авч сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлон, албадуудын ирүүлсэн сургалтын санал, газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заагдсан чиглэлийн дагуу "Албан хаагчдыг хөгжүүлэх, мэдлэг олгох, чадавхижуулах сургалтын 2024 оны төлөвлөгөө"-г 2024 оны 02 сарын 12-нд, гаалийн харилцаанд оролцогч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд чиглэсэн сургалт, арга хэмжээг тусад нь төлөвлөн "Гаалийн байгууллагын үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг олон нийтэд сурталчлах ажлын төлөвлөгөө"-г 2024 оны 02 сарын 28-нд тус тусад нь төлөвлүүлж батлуулан тайлангийн хугацаанд нийт 107 удаагийн сургалтыг зохион байгуулсан. -Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, сургалтын төлөвлөгдсөн хугацаа, хөтөлбөр, албан хаагчдын ирц, сургалтын чанар, нотломж, тайланд хяналт тавьж 2024 онд албан хаагчдад чиглэсэн 82, аж ахуйн нэгж, иргэдэд чиглэсэн 25 нийт 107 сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 7186 албан хаагч, 234 байгууллага, аж ахуйн нэгжийн 412 албан тушаалтан, ЕБС-ийн 2 сургуулийн 42 сурагч хамрагдсан. -Тус газрын албан хаагчид 2024 онд гаалийн хэргийн мэдлэг олгох чиглүүлэх сургалтад 6 албан хаагч, нарийн мэргэжлийн мэргэшүүлэх сургалтад 2 эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч, 2 архивын ажилтан, 6 ариутгагч, рентген төхөөрөмжийн чадавхижуулах сургалтад 48 гаалийн улсын байцаагч, цөмийн хяналтын чиглэлээр 2 гаалийн улсын байцаагч хамрагдаж мэргэшлийн болон чадамжийн сертификат авсан байна.	2024.01.01 2024.11.30	100

					<p>-Дэлхийн гаалийн байгууллагын цахим сургалт Click онлайн платформын сургалтуудад хорио цээрийн хяналт хариуцсан 31 гаалийн улсын байцаагч хамрагдаж 67 гэрчилгээ авч мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна.</p> <p>-“Албан хаагчдыг хөгжүүлэх, мэдлэг олгох, чадавхижуулах сургалтын төлөвлөгөө”-нд 2024 онд 43 сургалт зохион байгуулахаар төлөвлөснөөс 100 хувийн биелэлттэй бүрэн зохион байгуулсан бөгөөд нэмэлтээр /төлөвлөгөөнд тусгагдаагүй/ 39 сургалт зохион байгуулж албан хаагчдын хууль тогтоомж, журам, дүрэм, стандарт, тэдгээрийн шинэчлэл өөрчлөлт, гаалийн хяналт шалгалтын үр дүнг дээшлүүлэх, ТЖАХ-ийн болон гаалийн улсын байцаагчийн эрх, үүрэг, ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, харилцаа, хандлага, байгууллагын соёл, ХАБЭА, аюулгүй байдал, жендер, гамшиг, албан хэрэг хөтлөлт, эрүүл мэнд, хувь хүний хөгжилтэй холбоотой мэдлэг олгож соён гэгээрүүлэх чиглэлд түлхүү анхаарч ажилласан.</p> <p>-“Гаалийн байгууллагын үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг олон нийтэд сурталчлах ажлын төлөвлөгөө”-нд 2024 онд 16 сургалт зохион байгуулахаар төлөвлөж бүрэн, нэмэлтээр /төлөвлөгөөнд тусгагдаагүй/ 9 сургалт нийт 25 удаагийн сургалтыг зохион байгуулан гаалийн харилцаанд оролцогч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын албан хаагчдын хууль тогтоомж, гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлд голлон анхаарч ажилласан.</p> <p>-Хариуцсан ажлын чиг үүргийн хүрээнд сургалтын хөтөлбөр боловсруулах, зар мэдээлэл түгээх, сургалт хийх байгууллага, албан тушаалтнуудтай холбогдох, ирц бүртгэх, фото зураг авч баримтжуулах, сургалтын тайлан холбогдох материалыг хавсарган архивын нэгж болгох зэрэг ажлуудыг гүйцэтгэн ажиллаж байна.</p>	
--	--	--	--	--	--	--

3	"Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай" хуулийн хэрэгжилтийг хангах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1."Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай" хуулийн хэрэгжилтийг хангах ажлын 2024 оны төлөвлөгөө боловсруулж газрын даргаар батлуулсан байна 2.Төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг гүйцэтгэж эхний хагас жилд тайлагнасан байна.	Тус гаалийн газар Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, "Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 13 дахь заалтын хэрэгжилтийг хангах, албан хаагчдад Жендэрийн хууль тогтоомж, жендэрийн тухай ойлголт, тэгш байдал, ялгарварлан гадуурхалт, ажлын байрны дарамт, хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийг үл тэвчих талаарх ойлголт мэдлэг олгох, эерэг хандлага төлөвшүүлэх зорилгоор 9 ажил бүхий "ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ" боловсруулан 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. -"Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө"-ний дагуу Төв аймгийн Жендэрийн салбар хороотой хамтран нийт албан хаагчдад "Жендэрийн тэгш байдлыг хангах хууль, тогтоомж болон жендэрийн тухай ойлголт" сэдэвт танхимын сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан. Төв аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн дарга Д.Мөнхцэцэг, ЗХТ-ийн ахлах мэргэжилтэн Ц.Лхагва-Орлом нар "Жендэрийн хууль тогтоомж, жендэрийн хэвшмэл ойлголт, жендэрийн тэгш байдал, ялгарварлан гадуурхалт, ажлын байрны дарамт, хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийг үл тэвчих талаарх ойлголт мэдээлэл өгсөн. Сургалтад нийт 165 албан хаагч оролцсон. Төв аймгийн Жендэрийн салбар хорооноос тус гаалийн газарт Жендэрийн үндэсний хорооноос гаргасан "Харилцан хүндэтгэе" аяны хүрээнд зохион байгуулсан "Жендэрийн хэвшмэл ойлголт" сургалтад хамрагдсан "Батламж" олгосон. -Жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль, жендэрийн ойлголт, тэгш байдал, ялгарварлан гадуурхалт, ажлын байрны дарамт, хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийг үл тэвчих талаарх ойлголт, эерэг хандлага	2024.01.01 2024.11.30	100
---	---	-------------------------	---	---	--	--------------------------	-----

				<p>төлөвшүүлэх суурь мэдлэг олгох зорилгоор ГЕГ, “Жендэрийн Үндэсний Хороо” фэйсбүүк пэйж хуудсаар түгээсэн 13 мэдээ, мэдээллийг “Чингис хаан ОУНБ гаалийн газар” фэйсбүүк пэйж хуудас, албаны өрөөний мэдээллийн самбар, Чингис хаан олон улсын нисэх буудалд байрлах лэд дэлгэц зэрэгт байршуулж түгээсэн.</p> <p>-Албан хаагчдад ажлын байрны бэлгийн дарамт, жендэрийн тэгш байдал, ялгаврлан гадуурхахтай холбоотой гомдлыг ГЕГ-т Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын байцаагч, жендэрийн асуудал хариуцсан албан хаагч Б.Итэшмаа, тус гаалийн газарт гаалийн улсын байцаагч Б.Жаргалмаа хүлээн авах, “ажлын байрны бэлгийн дарамттай холбоотойгоор үүссэн зөрчил, хувь хүнтэй холбоотой аливаа мэдээллийг хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалж нууцлах тухай” мэдээллийг Spark, “Чингис хаан ОУНБ гаалийн газар дотоод сүлжээ” фэйсбүүк группт байршуулж түгээсэн. Тайлангийн хугацаанд бүртгэгдсэн гомдол байхгүй байна.</p> <p>Жендэрт суурилсан судалгаа хийсэн. Үүнд:</p> <p>1.Нийт албан хаагчдын нас, хүйс тодорхойлсон судалгаагаар 2024 оны 11 сарын 30-ны байдлаар 233 албан хаагч ажиллаж байгаагийн 138 нь эмэгтэй, 95 эрэгтэй, төрийн тусгай 200, төрийн үйлчилгээний албан хаагч 33 тус тус байна. Эрэгтэй, эмэгтэй албан хаагчийн хүйсийн харьцаа 59 : 41 байгаа нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад нийцэж байна. Удирдах тушаалтны эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа нийт 8, эрэгтэй 7 буюу 87 хувь, эмэгтэй 1 буюу 13 хувь байна.</p> <p>Гаалийн улсын ахлах байцаагчдын эрэгтэй эмэгтэй хүйсийн харьцаа нийт 16, эрэгтэй 9 буюу 56 хувь, эмэгтэй 7 буюу 44 хувь байна.</p> <p>Гаалийн улсын байцаагчдын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа нийт 173, эрэгтэй 62 буюу 36 хувь, эмэгтэй 111 буюу 64 хувь байна.</p> <p>2.Тус гаалийн газраас 2024 онд албан</p>	
--	--	--	--	--	--

					<p>хаагчдад эмэгтэй, эрэгтэй ажилтан гэж ялгалгүйгээр ажил, мэргэжлийн эрх ашиг, гэр бүлийн үүргээ хослуулах, хүүхэд төрүүлэх, асрах нөхцөл бололцоо олгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор цалинтай чөлөө 13, цалингүй чөлөө 3, чөлөөний хуудсаар 13 нийт 29 албан хаагчид 5-22 хоногийн чөлөө олгосон байна. Чөлөө авсан албан хаагчдын 31 хувь нь эрэгтэй, 69 хувь нь эмэгтэй албан хаагч байна.</p> <p>3.Албан хаагчдын дунд өвчлөлийн судалгаа хийж зонхилон тохиолдож буй өвчин эмгэгийг тодорхойлон зөвлөгөө өгч ажилласан. Судалгаагаар 13 төрлийн оношоор 105 албан хаагч эмнэлэгт хандан магадлагаа, лист авч эмчилгээ хийлгэсэн байна. Эмнэлэгт хандан магадлагаа, лист авсан албан хаагчдын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа эмэгтэй 67 буюу 63.8 хувь, эрэгтэй 38 буюу 36.19 хувь тус тус эзлэж байна. Нийт эрэгтэй албан хаагч дунд өвчлөл 40 хувь, эмэгтэй албан хаагч дунд өвчлөл 48.5 хувь байна.</p> <p>4.Тус гаалийн газарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 3 албан хаагч, Хөгжлийн бэрхшээлтэй, 50-90 хувийн хөдөлмөрийн чадвар алдалттай албан хаагч 3 буюу 1.3 хувийг эзлэж байна.</p> <p>5.Өрх толгойлсон хүүхэдтэй эх 28, эцэг 2 нийт 30 өрх толгойлсон хүүхэдтэй албан хаагч байна.</p> <p>Жендэрийн үндэсний хорооноос зарласан "Харилцан хүндлэе", "Шалтаг бүү тооч охид эмэгтэйчүүд хаана ч аюулгүй" 2 удаагийн аянд нэгдэн оролцсон.</p>		
4	Гаалийн ерөнхий газрын холбогдох нэгжээс ирүүлсэн зөвлөмж, үүрэг, даалгаврын хэрэгжилтийг хангахад дэмжлэг	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Гаалийн ерөнхий газрын бүтцийн нэгжүүдээс тус газарт 2023 оны жилийн эцсийн байдлаар онлайн хурлын даалгавар 30, зөвлөмж 44, үүрэг даалгавар 16, албан даалгавар 14-ыг оноосон ба ирүүлсэн нийт 104 үүрэг	Зөвлөмж, үүрэг, даалгаврын /онлайн/ хэрэгжилтийг хангах зорилгоор албадуудад танилцуулан биелэлтийг нэгтгэн тухай бүр SERP	-ГЕГ-ын 2024 оны 01 сарын 24-ний өдрийн 02/316 дугаар албан бичгийн дагуу тус газарт ажиллаж буй 19 гаалийн улсын ахлах байцаагч нарын ажилдаа хандах хандлага, мэргэжил, ёс зүй, ур чадварыг үнэлсэн үнэлгээний хуудас, энэ талаар хийсэн ажлын тайланг ГЕГ-т хүргүүлэх ажлыг гүйцэтгэсэн. -ГЕГ-ын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 01-1/324 дугаар албан бичгийн дагуу Гаалийн байгууллагын үйл ажиллагаа, холбогдох хууль	2024.01.01 2024.11.30	100

	үзүүлэх		<p>даалгавар зөвлөмжийн биелэлтийг чиглэл хариуцсан нэгж тус бүрээс гаргуулан авч нэгтгэн хугацаанд нь "Захиргаа, дотоод ажлын систем" программд тухай бүр хугацаанд оруулж дүгнүүлсэн.</p>	<p>программд оруулж ажиллана.</p>	<p>тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг олон нийтэд сурталчлан таниулах ажлын төлөвлөгөөний саналыг албадуудаас авч нэгтгэн ГЕГ-т хүргүүлсэн.</p> <p>-ГЕГ-ын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 01-4/329 дугаар албан бичгээр ирүүлсэн ГЕГ-ын даргын "Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал"-ыг батлах тухай А/238 дугаар тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг албад, албан хаагчдаас авч нэгтгэж хүргүүлэх чиглэлийг ГУБ Д.Ганпүрэвт хариуцуулсан.</p> <p>-ГЕГ-ын 2024 оны 02 сарын 27-ны өдрийн 01-1,1/742 дугаар албан бичгийн дагуу Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын бүрдүүлэлтийн албанд томилох албан хаагчдын саналыг ГЕГ-т хүргүүлсэн.</p> <p>-Орон даяар 2024 оны 03 сарын 28-ны өдрийн 16:00 цагт зарласан "Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулалт"-д Захиргааны байранд ажиллагсдыг хамруулж оролцох ажлыг Аж ахуй, хариуцсан зохион байгуулагч Б.Баасансүрэнгийн хамт зохион байгуулсан.</p> <p>-ГЕГ-аас Даваа гарагийн 10.00 цагт зохион байгуулдаг 9 удаагийн цахим хурлын ирцийг хүргүүлж, газрын болон Захиргааны албаны 7 хоногийн мэдээг нэгтгэж, удирдлагад танилцуулж ажилласан.</p> <p>-ГЕГ-ын даргын 2019 оны А/275 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-ыг албан хаагчдад танилцуулж, шинэчлэхээр боловсруулсан төсөлд санал авч нэгтгэн 2024.07.09-ны өдөр албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>-ГЕГ-ын Ёс зүйн хорооноос ирүүлсэн албан бичгийн дагуу албан хаагчдаас "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэх хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам" төсөлд санал авч нэгтгэн 2024.07.19-нд албан</p>		
--	---------	--	---	-----------------------------------	---	--	--

				<p>бичгээр хүргүүлсэн.</p> <p>-ГЕГ-ын ТЗУГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу албан хаагчдаас "Төрийн албаны үйл ажиллагааны стандартад тавих ерөнхий шаардлага MNS2024" стандартын төсөлд өгөх санал авч нэгтгэн 2024.07.22-нд хүргүүлсэн.</p> <p>-ГЕГ-ын Ёс зүйн хорооноос ирүүлсэн албан бичгийн дагуу нийт албан хаагчдад "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль", "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр", "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм", "Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм"-ийг уншиж, танилцах ажлыг зохион байгуулж, "Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм"-д оруулах нэмэлт, өөрчлөлтийн санал авч нэгтгэн албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>-“Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөөнд аудитын шалгалт” хийгдэж байгаатай холбогдуулан ГЕГ-т хүргүүлэх судалгааны үр дүнгийн үнэлгээг нэгтгэх ажлыг хариуцаж, 2024.10.05, 06-ны амралтын өдөр болон 2024.10.07-09-ний хооронд архивын 2019-2022 оны материалыг 10 сард ажиллаж байсан 231 албан хаагчийн үр дүнгийн үнэлгээг нэгтгэсэн.</p> <p>-СЕРП, Spark-аар нийт албан хаагчдад ирүүлсэн мэдээ, мэдээлэл, үүрэг даалгаврыг тогтмол түгээж ажилласан.</p> <p>-Газрын 2024 оны сургалтын төлөвлөгөөний биелэлт, сургалтын бичмэл тайланг гаргаж, удирдлагад танилцуулж, 2024.11.30-ны өдөр СЕРП-д байршуулсан.</p> <p>-Газрын “Гаалийн байгууллагын үйл ажиллагаа, хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлын төлөвлөгөөн”-ний биелэлт гаргаж, удирдлагаар хянуулж, хүргүүлсэн.</p> <p>-Газрын Жендэрийн төлөвлөгөөний биелэлт, бичмэл тайланг гаргаж удирдлагад танилцуулан хянуулж, 2024.11.30-ны өдөр СЕРП-д байршуулсан.</p> <p>-“Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг 16</p>	
--	--	--	--	---	--

					<p>хоногийн аян"-ы хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тайланг гаргаж, 2024.12.13-ны өдөр хянуулан ГЕГ-ын ХНХ-т хүргүүлсэн.</p> <p>-ГЕГ-ын ХБГ-т 2024.12.10-ны өдөр "Озон задалдаг бодисын импорт, экспортод тавих гаалийн хяналт болон гааль, хилийн хяналтын ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх" сургалтад оролцох 8 гаалийн улсын байцаагчийн нэрийг албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>-ГЕГ-ын ЗУГ-т 2024.12.12-ны өдөр "Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолыг үндэслэн шагнах шалгуур үзүүлэлт хангасан" албан хаагчдын нэрийг албан бичгээр хүргүүлсэн.</p>		
--	--	--	--	--	---	--	--

ХОЁР. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

1	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, тайлагнах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын баталсан 2020 оны "Аргачлал, загвар батлах тухай" 100 дугаар тушаалын дагуу Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан нэгжийн даргаар батлуулж, 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө-ний биелэлтийг хугацаанд нь тайлагнасан. ЗГХЭГ-ын даргын баталсан 2023 оны "Аргачлал, загвар батлах тухай" 98-р тушаалын дагуу 2023 оны Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө-ний биелэлтийг хугацаанд	1.Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна. 2.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж эхний хагас жилээр тайлагнаж дүгнүүлсэн байна. 3.Хариуцсан ажлын чиглэлээр эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж, тайлагнасан байна.	-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын баталсан 2020 оны "Аргачлал, загвар батлах тухай" 100 дугаар тушаалын дагуу Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан нэгжийн даргаар батлуулсан. -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын баталсан 2023 оны "Аргачлал, загвар батлах тухай" 98 дугаар тушаалын дагуу 2024 оны Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг эхний хагас жилээр болон жилийн эцсийн байдлаар гаргаж хугацаанд нь тайлагнасан.	2024.01.01 2024.11.30	100
---	---	-------------------------	--	--	--	--------------------------	-----

			нь тайлагнасан.				
2	Төрийн албаны тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Авлигын эсрэг хууль тогтоомжуудыг мөрдөж ажиллах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Авлигын эсрэг хуулийн хүрээнд 2022 оны хөрөнгө оруулгын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлсэн.	1.2023 оны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд мэдүүлж, баталгаажуулан, баталгааны маягтын ЭБАТ-нд хүлээлгэн өгсөн байна. 2.Тайлант хугацаанаас хойш ХАСХОМ-т орсон өөрчлөлтийг хуулийн хугацаанд мэдүүлсэн байна. 3.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээнд оролцсон байна.	-Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Авлигын эсрэг хуулийн хүрээнд 2023 оны хөрөнгө оруулгын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлсэн. -2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр тус гаалийн газрын ЭБАТ, ГУАБ Д.Хонгорзулын зохион байгуулсан "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, урьдчилан сэргийлэх" сэдэвт сургалт; -2024.06.06-ны өдөр мэдээллийн цагаар ЭБАТ, ГУАБ Д.Хонгорзулын зохион байгуулсан "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, урьдчилан сэргийлэх" сэдэвт цахим сургалт; -2024.10.29-ны өдөр ЭБАТ, Захиргаа, хүний хариуцсан ГУАБ Д.Хонгорзулын зохион байгуулсан "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, урьдчилан сэргийлэх" сэдэвт танхимын сургалтад тус тус хамрагдсан.	2024.01.01 2024.11.30	100
3	Архив, албан хэрэг хөтлөлтийг зохих заавар, журам, стандартад нийцсэн баримт бичиг боловсруулах хэрэгжилтийг ханган ажиллах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Газрын 2023 оны төлөвлөгөө, хагас жилийн тайлан, Бүх албадын төлөвлөгөө, төлөвлөгөө-ний хагас жилийн биелэлт, албан хаагчдын төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үнэлгээний хуудсуудын архивт хүлээлгэн өгсөн.	Архив, албан хэрэг хөтлөлт, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллана.	-Газрын 2023 оны авлигын эсрэг төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт, зохион байгуулсан ажлын тайлан зэрэг 2 боть материалыг холбогдох журмын дагуу цэгцлэж архив хүлээлгэн өгсөн. -ТЖАХ-ийн 2023 оны үнэлгээний хуудсыг холбогдох журмын дагуу цэгцлэж, 4 архивын нэгж болгон архивт өгсөн. -Архивт өгөгдсөн, товъег буруу хийгдсэн 2023 оны албан хаагчдын сарын ажлын тайлангийн 17 боть архивын нэгжийг буцаан авч засч хүлээлгэн өгсөн. -"Төрийн жинхэнэ албан хаагчийн болон Төрийн үйлчилгээний албан хаагчдийн 2024 оны 01 дүгээр сарын ажлын тайланг хүлээн авч архивын нэгж болгон архивт хүлээлгэн өгсөн. -Газрын 2024 оны сургалтын төлөвлөгөө, биелэлт, сургалтын хөтөлбөр, бусад нотломж, баримтыг архивын нэгж болгон архивт	2024.01.01 2024.11.30	100

					<p>хүлээлгэн өгсөн.</p> <p>-Газрын 2024 оны Жендэрийн төлөвлөгөөний биелэлт, зохион байгуулсан ажлын нотлох баримтыг архивын нэгж болгон архивт хүлээлгэж өгсөн.</p> <p>-Албан хаагчдын 1-12 дугаар сарын ажлын тайланг хүлээн авч, цэгцлэн, архивын нэгж болгон хүлээлгэн өгсөн.</p>		
4	<p>Гаалийн хяналт шалгалттай холбоотой гаалийн удирдах төв байгууллага болон газрын удирдлагаас өгсөн удирдамж, үүрэг даалгаврын биелэлтийн хэрэгжилтийг хангах</p>	<p>Үүрэг даалгаврын биелэлт, үр дүнгээр</p>	<p>Тус гаалийн газарт 2023 оны жилийн эцсийн байдлаар 30 онлайн хурлын даалгавар, 44 зөвлөмж, 16 үүрэг даалгавар, 14 албан даалгавар нийт 104 үүрэг даалгавар ирүүлснийг холбогдох алба, хариуцсан албан тушаалтанд хүргүүлж, биелэлтийг гаргуулан нэгтгэж хугацаанд нь "Захиргаа, дотоод ажлын систем" программд оруулж, дүгнүүлж ажилласан.</p> <p>- ГЕГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2023.05.18-ны өдрийн дотоод аудитын удирдамжийн дагуу хийсэн шалгалтын зөвлөмжийн хүрээнд 2 төлөвлөгөө боловсруулан биелэлтийг гарган албан бичгээр хүргүүлж СЕРП программд байршуулсан.</p> <p>- Монгол улсын 2023 оны "Төсвийн тухай хууль" болон Сангийн сайдын "Төсвийн</p>	-	<p>хүлээлгэн өгсөн.</p> <p>-ГЕГ-ын 2024 оны 01 сарын 24-ний өдрийн 02/316 дугаар албан бичгийн дагуу тус газарт ажиллаж буй 19 гаалийн улсын ахлах байцаагч нарын ажилдаа хандах хандлага, мэргэжил, ёс зүй, ур чадварыг үнэлсэн үнэлгээний хуудас, энэ талаар хийсэн ажлын тайланг ГЕГ-т хүргүүлэх ажлыг гүйцэтгэсэн.</p> <p>-ГЕГ-ын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 01-1/324 дугаар албан бичгийн дагуу Гаалийн байгууллагын үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг олон нийтэд сурталчлан таниулах ажлын төлөвлөгөөний саналыг албадуудаас авч нэгтгэн ГЕГ-т хүргүүлсэн.</p> <p>-Газрын даргын 2023 оны А/37 дугаар тушаалаар 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх, хянаж баталгаажуулах, мэдээлэх үнэлгээний багийн нарийн бичгийн даргаар томилогдон нийт албан хаагчдын үнэлгээг алба тус бүрээс авч нэгтгэх, баталгаажуулах ажлыг гүйцэтгэж, архивт шилжүүлсэн.</p> <p>-"Төрийн жинхэнэ албан хаагчийн болон Төрийн үйлчилгээний албан хаагчдийн 2024 оны 01 дүгээр сарын ажлын тайланг хүлээн авч архивын нэгж болгон архивт хүлээлгэн өгсөн.</p> <p>-Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын 2024 оны "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах" чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулсан.</p> <p>-Захиргааны албаны ажил үүргийн хуваарийн дагуу албан хаагчдад зохион байгуулдаг сургалтын асуудлыг хариуцан санал авах ажлыг албадуудад дотоод зурвасаар, албан хаагчдад ЧХОУНБ гаалийн газар Дотоод сүлжээ</p>	<p>2024.01.01 2024.11.30</p>	100

		<p>хуваарь батлах тухай” 2022.12.30-ны өдрийн 285 дугаар тушаал, Гаалийн ерөнхий газрын даргын 2023.09.04-ний өдрийн “Улсын төсвийн гаалийн орлогын сар, улирлын хуваарь батлах тухай” А/439 тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор ГЕГ-ын даргын 01, 05 дугаар албан даалгаврыг хүлээн авч, тодорхой ажлуудыг зохион байгуулан хэрэгжүүлж, 7 хоног бүрийн 5 дахь өдрийн онлайн хуралд тайлагнаж, төлөвлөгөө боловсруулан 11 заалт 86 хуудас бүхий биелэлтийг Татвар, тарифын газарт хүргүүлж ажилласан.</p>		<p>фэйсбүүк хуудсаар авахаар зохион байгуулж, ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулж Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын 2024 оны сургалтын төлөвлөгөөг батлуулсан.</p> <p>-ГЕГ-ын 2024 оны 02 сарын 27-ны өдрийн 01-1,1/742 дугаар албан бичгийн дагуу Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын бүрдүүлэлтийн албанд томилох албан хаагчдын саналыг ГЕГ-т хүргүүлсэн.</p> <p>-Захиргааны байранд зохион байгуулах “Цагаан сарын золголт”-ыг зохион байгуулсан.</p> <p>-Гаалийн улсын байцаагч нарт олгох албаны цамцны захиалга авах ажлыг зохион байгуулсан.</p> <p>-ГЕГ-ын даргын 2024 оны А/123 дугаар тушаалын дагуу Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын бүтэц орон тооны судалгааг шинэчлэн удирдлагад танилцуулсан.</p> <p>-Архивт өгөгдсөн, товъег буруу хийгдсэн 2023 оны албан хаагчдын сарын ажлын тайлангийн 17 боть архивын нэгжийг буцаан авч засч хүлээлгэн өгсөн.</p> <p>-Нийт албан хаагчдын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг албадын дарга, гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч, Төрийн үйлчилгээний албан хаагч тус бүрээр хавтас үүсгэн нэрсийн дарааллаар байрлуулан ГУБ Д.Отгонтөгст хүлээлгэн өгсөн.</p> <p>-Орон даяар 2024 оны 03 сарын 28-ны өдрийн 16:00 цагт зарласан “Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилт”-д Захиргааны байранд ажиллагсдыг хамруулж оролцох ажлыг Аж ахуй, хариуцсан зохион байгуулагч Б.Баасансүрэнгийн хамт зохион байгуулсан.</p> <p>-ГЕГ-аас Даваа гарагийн 10.00 цагт зохион байгуулдаг 9 удаагийн цахим хурлын ирцийг хүргүүлж, газрын болон Захиргааны албаны 7 хоногийн мэдээг нэгтгэж, удирдлагад танилцуулж ажилласан.</p> <p>-“Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК”, “Төв аймгийн Нийгмийн даатгалын</p>	
--	--	--	--	---	--

					<p>газар", "Төв аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар"-тай хамтран 2024 оны 05-р сарын 15-ны өдөр "Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн мэдлэг олгох сургалт"-ыг зохион байгуулсан.</p> <p>-СЕРП, Spark-аар нийт албан хаагчдад ирүүлсэн мэдээ, мэдээлэл, үүрэг даалгаврыг тогтмол түгээж ажилласан.</p> <p>-Авиа компаниудад зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулан батлуулж, 2024.06.06-ны өдөр хилийн хяналтын байгууллагуудын нэгдсэн байрны 4 давхрын хурлын танхимд зохион байгуулсан.</p> <p>-Мэдээллийн цагийг 2024.06.06-ны өдөр зохион байгуулж "Төрийн албан хаагчийн ёс зүй", "Архив, албан хэрэг хөтлөлт, албан бичгийн стандарт, албан бичиг боловсруулах", "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, урьдчилан сэргийлэх" сэдэвт цахим сургалт хийсэн.</p> <p>-Газрын "Гаалийн байгууллагын үйл ажиллагаа, хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлын төлөвлөгөөн"-ний биелэлт гаргаж, удирдлагаар хянуулж, хүргүүлсэн.</p> <p>-Архивын ерөнхий газартай хамтран "Баримт бичгийн стандарт, баримт бичгийг зохион бүрдүүлэх арга зүй" сэдвээр сургалт хийх ажлыг зохион байгуулсан.</p> <p>-Захиргааны албаны ажил хариуцсан гаалийн улсын байцаагчийн технологи ажиллагааны заавар боловсруулж албаны дарга С.Батдамбад танилцуулсан.</p> <p>-НУБИА ХХК-аас зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгт оролцох ГУАБ, ГУБ нарт холбогдох мэдээллийг хүргэж, бэлтгэлийг хангуулж ажилласан.</p> <p>-Чингис хаан олон улсын нисэх буудалд 2024.09.16-ны өдөр "Төрийн далбаа мандуулах ёслол"-д гаалийн байгууллагыг төлөөлж оролцох албан хаагчдын нэрсийн жагсаалтыг гаргаж зохион байгуулсан.</p>	
--	--	--	--	--	--	--

					-Газрын даргын өгсөн үүрэг чиглэлийн дагуу 1 удаагийн удирдлагын хурал, 2 удаагийн албадын дарга, ахлахуудын хурлын тэмдэглэл хөтлөж, баталгаажуулсан.		
5	Гаалийн ерөнхий газар болон бусад холбогдох байгуулагаас зохион байгуулсан хурал, сургалт, олон нийтийг хамруулсан арга хэмжээнд оролцох	Байгуулсан арга хэмжээ, хурал цуглаанд оролцсон байдал, тоо	Тайлант хугацаанд ЧХОУНБГГ бусад байгууллагаас зохион байгуулсан танхимын 8, цахим 3 нийт 11 сургалтад хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлсэн. Хамт олныг хамарсан мод тарих ажиллагаа, эрүүл мэндийн үзлэг, "Зуны зугаатай өдөр" арга хэмжээг зохион байгуулсан.	Гаалийн ерөнхий газар болон бусад холбогдох байгуулагаас зохион байгуулсан хурал, сургалт, олон нийтийг хамруулсан арга хэмжээнд оролцож холбогдох шийдвэрүүдийг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж, хэвшүүлж хэрэгжүүлнэ.	Тус гаалийн газрын 2024 оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан 20 удаагийн танхимын болон цахим сургалтыг зохион байгуулж, хамрагдсан. -Удирдлагын академиас 2024.01.30-ны өдөр зохион байгуулсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, анхаарах асуудлууд"; -Хилийн цэргийн 0218 дугаар ангиас зохион байгуулсан "Боомтод мөрдөх журам"; -ИАТЦХ-ээс зохион байгуулсан "Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, анхаарах асуудлууд"; -ТЕГ-ын СТА-наас зохион байгуулсан "Тэсэрч дэлбэрэх бодисын талаарх ойлголт"; -НУБИА ХХК-иас зохион байгуулсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдох хууль тогтоомж, дүрэм, зааврын талаарх ойлголт"; -Төв аймгийн Жендерийн салбар зөвлөлөөс зохион байгуулсан "Жендерийн тэгш байдлыг хангах хууль, тогтоомж болон жендерийн тухай ойлголт"; -Тээврийн прокурорын газраас зохион байгуулсан "Зөрчил шалган шийдвэрлэх явцад анхаарах зүйл"; -Төв аймгийн НДХ-ээс зохион байгуулсан "Нийгмийн даатгалын холбогдолтой хууль тогтоомжийн шинэчлэл"; -ГЕГ-аас зохион байгуулсан "VR технологид суурилсан сургалтын танилцуулга", "VR технологид суурилсан сургалт"; -ГЕГ-аас зохион байгуулсан "Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагаанд анхаарах зарим асуудлууд" сэдэвт танхимын сургалтуудад тус тус хамрагдсан. -ГЕГ-аас зохион байгуулсан "Төрийн албан	2024.01.01 2024.11.30	100

				<p>хаагч өндөр насны тэтгэвэрт гарахад олгох 1 удаагийн буцалтгүй тусламжийн талаарх" цахим сургалт;</p> <p>-ТАЗ-аас Пүрэв гараг бүрт зохион байгуулдаг 7:4:10 цахим сургалт;</p> <p>-ГЕГ-ын ХЦГ-аас 2024 оны 03 сарын 12-ны өдөр зохион байгуулсан цахим хуралд;</p> <p>-ГЕГ-аас зохион байгуулсан Удирдах ажилтны зөвлөгөөн;</p> <p>-Архивын ерөнхий газраас 2024 оны 03 сарын 11-12-нд зохион байгуулсан "Баримт бичгийн стандарт, баримт бичгийг зохион бүрдүүлэх арга зүй" сэдэвт мэргэшүүлэх цахим сургалт;</p> <p>-ГЕГ-аас 2024.03.07-ны өдөр зохион байгуулсан "Гаалийн мэргэшил ба эмэгтэйчүүд" сэдэвт цахим сургалт;</p> <p>-ГЕГ-аас 2024.09.17-нд зохион байгуулсан "Ёс зүйн чиг хандлагыг төлөвшүүлэх замаар авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх" сэдэвт танхимын сургалт ;</p> <p>-Тус газрын ёс зүйн дэд хорооноос 2024.10.29-нд зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага, төрийн албаны хууль тогтоомж" сэдэвт танхимын сургалт;</p> <p>-НУБИА ХХК-иас 2024.11.18-нд зохион байгуулсан HR consulting firm компанийн "Аз жаргалтай ажилтан, Үйлчилгээний сахилга бат, Хандлагын хүч" сэдэвт сургалт;</p> <p>-ГЕГ-ын Хорио цээрийн хэлтсээс 2024.11.13-ны өдөр зохион байгуулсан "Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, хариу арга хэмжээ" сэдэвт сургалт;</p> <p>-Тус газрын ёс зүйн дэд хорооноос 2024.11.22-ны өдөр Захиргааны албан хаагчдад танхимаар зохион байгуулсан "Ёс зүйн сургалт"-д ту тус хамрагдсан.</p> <p>Мөн байууллагаас 2024 онд зохион байгуулсан 82 сургалтад хамрагдаж мэдлэг, чадвараа дээшлүүлсэн.</p>	
--	--	--	--	---	--

Хоёр.Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (Биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн Хувь
			1	2	3	4	5
1	Жендэрийн тэгш эрхийг хангах чиглэлээр мэдлэг олгох сургалтад хамрагдах		-	Танхимын болон цахим сургалтад хувиараа хамрагдсан байна.	-Төв аймгийн Жендэрийн салбар хорооноос 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан "Жендэрийн тэгш байдлыг хангах хууль, тогтоомж болон жендэрийн тухай ойлголт" сэдэвт танхимын сургалтад хамрагдсан.	2024.01.01 2024.06.25	100
2	Баримт бичгийн стандарт, баримт бичгийг зохион бүрдүүлэх арга зүй сургалтад хамрагдах	Архив, албан хэрэг хөтлөлтийн анхан шатны сургалтад хамрагдаж төгссөн	-	АЕГ-аас зохион байгуулах 24 цагийн сургалтад хамрагдсан байна.	Архивын ерөнхий газраас 2024 оны 03 сарын 11, 12-ны өдрүүдэд зохион байгуулсан "Баримт бичгийн стандарт, баримт бичгийг зохион бүрдүүлэх арга зүй" сэдэвт мэргэшүүлэх цахим сургалтад хамрагдсан.	2024.01.01 2024.06.25	100

ТАЙЛАН ГАРГАСАН:
ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/Д.ГАНПҮРЭВ/

2024.12.13
.....
(огноо)

**ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДАЛ ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН
ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ДЭНДЭВИЙН ГАНПҮРЭВИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН
ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар

Нэгжийн нэр: Захиргааны алба

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх” зорилтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.1	Газрын даргын гаргасан тушаалыг хянуулсан байдал	53	9	62	
1.2	Төрийн үйлчилгээний албан тушаалын нөхөн хангалт, хөдөлмөрийн гэрээний хэрэгжилт	54	10	64	
1.3	Гаалийн ерөнхий газрын холбогдох нэгжээс ирүүлсэн зөвлөмж, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх	52	8	60	
Зорилт 2. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” зорилтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
2.1	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах батлуулах, тайлагнах	52	10	62	
2.2	Төрийн албаны тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Авлигын эсрэг хууль тогтоомжуудыг мөрдөж ажиллах	52	9	61	
2.2	Архив, албан хэрэг хөтлөлтийг зохих заавар, журам, стандартад нийцсэн баримт бичиг боловсруулах хэрэгжилтийг ханган ажиллах	53,7	9	62,7	
2.3	Гаалийн удирдах төв байгууллагын холбогдох нэгжээс ирүүлсэн зөвлөмж, үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах, тайлагнах	53	10	63	
2.4	Гаалийн ерөнхий газар болон бусад холбогдох байгууллагаас зохион байгуулсан хурал, сургалт, олон нийтийг хамруулсан арга хэмжээнд оролцох	52	10	62	
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт					
1.	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх, олон нийтийг хамруулсан арга хэмжээ зохион байгуулах, оролцох	52	10	62	
Дундаж оноо:		564/91	62,7		

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
		1	2	3
1.	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах	1	14	
2	Жендэрийн тэгш эрхийг хангах чиглэлээр мэдлэг олгох сургалтад хамрагдах		13	
3	Баримт бичгийн стандарт, баримт бичгийг зохион бүрдүүлэх аргазүй сургалтад		15	
Дундаж оноо			13	

3.Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
		1	2
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Дүн шинжилгээ хийх	7	
3.	Асуудал шийдвэрлэх	7	
4.	Хариуцлагатай байдал	7	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.		
7.	Мэргэжлийн ур чадвар 2.		
8.	Мэргэжлийн ур чадвар 3.		
Дундаж оноо		7	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
		1
1.	Хандлага, ёс зүй	7,3
2.	Багаар ажиллах	7,3
3.	Харилцаа	7,4
Дундаж оноо		7,3

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	62,7
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	13
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	7
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	7,3
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо =(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		90

Үнэлгээ өгсөн: Нэгжийн дарга
Захиргааны албаны дарга
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

С.Батдамба
(овог, нэр)

.....
(огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**
Гаалийн улсын байцаагч
(албан тушаал)

Төрийн жинхэнэ албан хаагч:

.....
(гарын үсэг)

Д.Ганпүрэв
(овог, нэр)

2024.12.20

.....
(огноо)

Үнэлгээг хянасан:
Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:
Хорио цээрийн албаны дарга
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

Б.Отгонцэцэг
(овог, нэр)

.....
(огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:
Захиргаа, хүний нөөц хариуцсан
гаалийн улсын ахлах байцаагч
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

Д.Хонгорзул
(овог, нэр)

.....
(огноо)

Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч

Газрын дарга
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

Г.Баасандорж
(овог, нэр)

.....
(огноо)